



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41  
И-мэйл: contact@afsc.gov.mn, Вэбсайт: www.afsc.gov.mn

2020. 04. 29 № 01/215  
Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тендерийн баримт бичгийг  
хянасан тухай

ХОВД АЙМГИЙН ОРОН  
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ

Х. Энхтүвшин-Орш  
Хуучин хэрэг  
Шийдвэр эх. харвал  
Олох Ш. М

Танай газраас зарласан Цэцэрлэгийн барилга, 240 ор /Ховд, Жаргалант сум, 9 дүгээр цэцэрлэг/ БСШУСЯ/202001312 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг "Баганат Орд" ХХК-иас тус газарт ирүүлсний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хянан үзлээ.

Тендерийн баримт бичгийн ТӨӨЗ 5.3 (д)-д "Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: 1 000 000 000 төгрөгнөөс багагүй байх. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр тодорхойлно. 1. Байгууллагын дансны үлдэгдэл /харилцагч банкны/ 2. Арилжааны банкны зээлийн хорооны зээл олгохоор гаргасан шийдвэр хавсаргах шаардлагатай /судлаж үзээд зээл олгох боломжтой албан бичгийг үнэлгээнд тооцохгүй болно" гэж заажээ.

1. Тендерийн баримт бичгийн ТӨӨЗ 2.1-д "Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2 600 000 000 төгрөг 2020 онд санхүүжих нь 1 000 000 000 төгрөг байна" гэж заасан байна. 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн Үнэлгээний хорооны хурлаар 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр зарласан тендерийн баримт бичгийн ТӨӨЗ 5.3 (д)-д "Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: 780 000 000 төгрөгнөөс багагүй байх ..." гэснийг "Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: 1 000 000 000 төгрөгнөөс багагүй байх ..." гэж үндэслэлгүйгээр өөрчлөлт оруулсан байна.

2. Үнэлгээний хорооны 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаар "Дахин хуралдсан хурлын тэмдэглэл"-ээс харвал тендер нээх хугацааг 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т "Захиалагч тендер оролцогчдод тендер бэлтгэж ирүүлэх хангалттай, ижил хугацаа олгоно" гэж заасныг зөрчиж тендер шалгаруулалтад оролцох сонирхолтой этгээдүүдэд ТӨӨЗ 5.3 (д)-д заасан арилжааны банкны зээлийн хорооны зээл олгохоор гаргасан шийдвэрийг ирүүлэх хангалттай хугацааг олгоогүй байна.

3. Захиалагч нь Тендерийн баримт бичгийн ТӨӨЗ 5.3 (д)-д "... Арилжааны банкны зээлийн хорооны зээл олгохоор гаргасан шийдвэр хавсаргах шаардлагатай" гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

00 2388

худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Захиалагч тендерт оролцогчоос гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн чадавхтайгаа баталсан нотолгоо ирүүлэхийг шаардаж болно" гэж, 15.3-т "Санхүүгийн чадавхийг дараахь баримт бичгээр нотолж болно" гэж, 15.3.1-т "харилцагч банкны мэдэгдэл" гэж тус тус заасныг зөрчиж тендер шалгаруулалтад оролцох сонирхолтой этгээдүүдээс хуульд заагаагүй нотолгоо ирүүлэхийг шаардсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой... хариуцлагатай байх зарчмыг баримтлана" гэж заасныг зөрчиж тендер шалгаруулалтад оролцох сонирхолтой этгээдүүдийн өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.3 дахь заалтыг үндэслэн тендерийн баримт бичигт холбогдох өөрчлөлт оруулан, хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгдэн, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу.

ДАРГА

Б.ЛХАГВА

